

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/258/ НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/91

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 118,839.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020098

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэг “Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85,8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>122,566,108.38</u> | <u>149,456,934.79</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 101,545,580.78 | 118,839,400.19 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 101,545,580.78 | 118,839,400.19 |
| 3121 | Төгрөг | 101,545,580.78 | 118,839,400.19 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 101,545,580.78 | 118,839,400.19 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 21,020,527.60 | 30,617,534.60 |
| 354 | Хангамжийн материал | 21,020,527.60 | 30,617,534.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 839,100.00 | 839,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,021,750.00 | 2,421,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 670,900.00 | 1,282,530.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,488,777.60 | 26,074,154.60 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>694,308,483.10</u> | <u>663,265,097.81</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 694,308,483.10 | 663,265,097.81 |
| 392 | Биет хөрөнгө | 682,188,483.10 | 651,145,097.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 747,138,884.20 | 747,138,884.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (80,871,503.76) | (110,925,450.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 58,886,596.01 | 60,623,796.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (46,606,605.43) | (48,931,334.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,019,090.00 | 7,019,090.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,377,977.92) | (3,779,886.96) |
| 393 | Биет бус хөрөнгө | 12,120,000.00 | 12,120,000.00 |
| 39301 | Программ хангамж | 628,000.00 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (628,000.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,120,000.00 | 12,120,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>816,874,591.48</u> | <u>812,722,032.60</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>3,694,876.00</u> | <u>3,694,459.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,694,876.00 | 3,694,459.00 |
| 413 | Өглөг | 3,694,876.00 | 3,694,459.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,694,876.00 | 3,694,459.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>813,179,715.48</u> | <u>809,027,573.60</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 813,179,715.48 | 809,027,573.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 232,742,753.55 | 232,742,753.55 |
| 51101 | Өмч: - төрийн | 232,742,753.55 | 232,742,753.55 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 174,610,165.07 | 170,458,023.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (142,997,231.77) | 174,610,165.07 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 317,607,396.84 | (4,152,141.88) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 405,826,796.86 | 405,826,796.86 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>816,874,591.48</u> | <u>812,722,032.60</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 738,900,674.00 | 533,872,177.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 245,564,674.00 | 5,388,877.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 245,564,674.00 | 5,388,877.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 245,564,674.00 | 5,388,877.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 245,564,674.00 | 5,388,877.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 493,336,000.00 | 528,483,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 399,927,700.00 | 471,287,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 399,927,700.00 | 471,287,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,917,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,917,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 66,491,300.00 | 57,195,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 66,491,300.00 | 57,195,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 421,328,277.16 | 538,024,318.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 421,328,277.16 | 538,024,318.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 391,133,903.85 | 537,592,924.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 215,510,608.67 | 317,000,056.65 |
| 210101 | Үндсэн цалин | 175,503,717.46 | 239,614,282.42 |
| 210102 | Нэмэгдэл | 32,509,914.64 | 69,456,315.55 |
| 210104 | Урамшуулал | 7,496,976.57 | 7,929,458.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,571,486.16 | 40,311,923.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,446,101.21 | 27,480,703.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,573,368.35 | 3,264,173.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,767,765.12 | 2,621,888.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434,932.27 | 628,245.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,349,319.21 | 6,316,913.02 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50,766,427.08 | 56,263,688.18 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,403,451.08 | 4,196,335.18 |
| 210302 | Түлш, халаалт | 48,162,976.00 | 51,867,353.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,889,600.00 | 9,768,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,414,500.00 | 3,017,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,031,500.00 | 3,388,825.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,443,600.00 | 3,362,575.00 |
| 2105 | Нормативт зардал | 57,514,025.00 | 71,422,570.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,514,025.00 | 71,422,570.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 381,000.00 | 1,136,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 381,000.00 | 1,136,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,000,756.94 | 41,189,585.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,636,000.00 | 6,922,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 716,000.00 | 886,900.00 |
| 210903 | үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,648,756.94 | 33,380,585.29 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,194,373.31 | 431,394.82 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,813,500.00 | - |

| | | | |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,356,500.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,457,000.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,380,873.31 | 431,394.82 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,380,873.31 | 431,394.82 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>317,572,396.84</u> | <u>(4,152,141.88)</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>317,572,396.84</u> | <u>(4,152,141.88)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | <u>493,336,000.00</u> | <u>528,483,300.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>493,336,000.00</u> | <u>528,483,300.00</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 399,927,700.00 | 471,287,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 399,927,700.00 | 471,287,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,917,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 66,491,300.00 | 57,195,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 66,491,300.00 | 57,195,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | <u>388,671,219.22</u> | <u>509,884,280.59</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>388,671,219.22</u> | <u>509,884,280.59</u> |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | <u>358,476,845.91</u> | <u>509,452,885.77</u> |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 215,622,270.72 | 317,398,967.79 |
| 210101 | Үндсэн цалин | 175,628,675.94 | 235,895,217.55 |
| 210102 | Нэмэгдэл | 32,496,618.21 | 73,574,291.56 |
| 210104 | Урамшуулал | 7,496,976.57 | 7,929,458.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,459,824.11 | 39,913,012.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,633,001.17 | 27,256,209.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,274,806.34 | 3,235,309.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,767,765.12 | 2,525,827.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434,932.27 | 624,381.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,349,319.21 | 6,271,284.57 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47,071,551.08 | 56,264,105.18 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,403,451.08 | 4,196,335.18 |
| 210302 | Түлш, халаалт | 44,468,100.00 | 51,867,770.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 103,500.00 | - |
| 2105 | Нормативд зардал | 54,161,700.00 | 72,034,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 54,161,700.00 | 72,034,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 381,000.00 | 1,136,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 381,000.00 | 1,136,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,177,000.00 | 22,206,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,977,000.00 | 18,797,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 3,408,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | <u>30,194,373.31</u> | <u>431,394.82</u> |

| | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,813,500.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,380,873.31 | 431,394.82 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,380,873.31 | 431,394.82 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>104,664,780.78</u> | <u>18,599,019.41</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 3,154,200.00 | 1,305,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,154,200.00 | 1,305,200.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>(3,154,200.00)</u> | <u>(1,305,200.00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 101,510,580.78 | 17,293,819.41 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 101,545,580.78 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 101,545,580.78 | 118,839,400.19 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|------------------------|--|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 232,742,753.55 | 405,826,796.86 | -142,997,231.77 | 495,572,318.64 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 232,742,753.55 | 405,826,796.86 | -142,997,231.77 | 495,572,318.64 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 317,607,396.84 | 317,607,396.84 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 232,742,753.55 | 405,826,796.86 | 174,610,165.07 | 813,179,715.48 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 232,742,753.55 | 405,826,796.86 | 174,610,165.07 | 813,179,715.48 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -4,152,141.88 | -4,152,141.88 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 232,742,753.55 | 405,826,796.86 | 170,458,023.19 | 809,027,573.60 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хувь |
|-----------------------|---|-----------------------|----------------|--------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 511,873,100.00 | 510,758,085.77 | 99.78 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 511,873,100.00 | 510,758,085.77 | 99.78 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 511,873,100.00 | 510,758,085.77 | 99.78 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 319,448,700.00 | 317,398,967.79 | 99.36 |
| 210101 | Үндсэн цалин | 246,545,200.00 | 235,895,217.55 | 95.68 |
| 210102 | Нэмэгдэл | 72,903,500.00 | 73,574,291.56 | 100.92 |
| 210104 | Урамшуулал | - | 7,929,458.68 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,716,700.00 | 39,913,012.80 | 98.03 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,687,300.00 | 27,256,209.94 | 98.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,257,400.00 | 3,235,309.09 | 99.32 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,605,800.00 | 2,525,827.45 | 96.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 651,500.00 | 624,381.75 | 95.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,514,700.00 | 6,271,284.57 | 96.26 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,695,500.00 | 56,264,105.18 | 99.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,627,700.00 | 4,196,335.18 | 90.68 |
| 210302 | Түлш, халаалт | 51,867,800.00 | 51,867,770.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 70,876,800.00 | 72,034,200.00 | 101.63 |
| 210502 | Хоол, хүнс | 70,876,800.00 | 72,034,200.00 | 101.63 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 500,000.00 | 500,000.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,136,300.00 | 1,136,300.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,136,300.00 | 1,136,300.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,499,100.00 | 23,511,500.00 | 104.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,090,200.00 | 20,102,600.00 | 105.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,408,900.00 | 3,408,900.00 | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 511,873,100.00 | 510,758,085.77 | 99.78 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 454,677,600.00 | 453,993,980.59 | 99.85 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 454,677,600.00 | 453,993,980.59 | 99.85 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 57,195,500.00 | 56,764,105.18 | 99.25 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 57,195,500.00 | 56,764,105.18 | 99.25 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 101,545,580.78 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 118,839,400.19 | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Цээл сумын цэцэрлэг нь 1975 онд 1 багш 1 бүлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино.

Хүүхдийн цэцэрлэг зорилгоо хэрэгжүүлэн ажиллахдаа хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллана.

Тус цэцэрлэг нь 2023 онд 22 ажиллагсадтай 12 зорилт төлөвлөж ажилласнаас 90 хувийн биелэлтэй ажиллаж байна.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн авьяас чадварыг илрүүлэх, хөгжүүлэх зорилгоор 9 төрлийн дугуйлан хичээллэдэг ба бүтэн жилийн турш сурч мэдсэн зүйлсээрээ үзэсгэлэн гарган ур чадварын тэмцээн уралдаанд оролцдог.

2023 оны “ЯРГУЙ” бага наадамд манай цэцэрлэгийн бүжгийн дугуйлангийн сурагчид хамтлаг бүжиг, гоцлол бүжиг, гоцлол дууны төрөлд оролцсоноос хамтлаг бүжгийн төрөлд МӨНГӨН МЕДАЛЬ аван маш сайхан амжилтыг үзүүлсэн. Бүлгийн багш нарын зохион байгуулан явуулдаг аян-6 төрлөөр үйл ажиллагаа нь байнга явагдаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэг нь Боловсрол шинжлэх ухааны ерөнхий газрын харьяа сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага юм.

Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт оруулсан. Үүнд:

- Төсвийн тухай хууль нэмэлт өөрчлөлт
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр,
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулсан.
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль нэмэлт өөрчлөлт
- Зөвшөөрлийн тухай хууль нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

Төв аймгийн Баянхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,152.6 мянган төгрөгөөр буюу 0,5 хувир буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|---------------------|--------------------|------------------|-----------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 101,545.6 | 118,839.4 | 17,293.8 |
| Авлага | | | |
| Бараа материал | 21,020.5 | 30,617.5 | 9,597.0 |
| Үндсэн хөрөнгө | 694,308.5 | 663,265.1 | -31,043.4 |
| Нийт хөрөнгө | 816,874.6 | 812,722.0 | -4,152.6 |
| Өр төлбөр | 3,694.9 | 3,694.4 | -0.5 |

| | | | |
|--|------------------|------------------|-----------------|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 813,179.7 | 809,027.6 | -4,152.1 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 816,874.6 | 812,722.0 | -4,152.6 |

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 17,0 хувиар өссөн байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 45,7 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 21,020.5 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 89,179.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 4,356.9 мянган төгрөг нийт 93,536.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 83,939.8 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 30,617.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 890,035.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд худалдан авсан 1,305.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 1,032.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмж, 1,228.0 мянган төгрөгийн хөрөнгийг актлан хасаж бүртгэсэн байна. Нийт үндсэн хөрөнгө 31,043.4 мянган төгрөгөөр буурсан байна.

- Өглөгийн талаар: Тайлант хугацааны эцэст 3,6954.4 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны алдагдлыг 4,152.1 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 572,833.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 572,833.4 мянган төгрөгөөр тооцон 2022 оны 7 дугаар сарын 19 өдрийн 04 албан тоотой төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 60,960.3 мянган төгрөгөөр бууруулж, 511,873.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсрол-71801 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 453,994.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,764.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 510,758.1 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 1,115.0 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|------------|-----------|----------|---------|
| 1 | Сургуулийн өмнөх боловсрол-71801 | 511,873.1 | 510,758.1 | 1,115.0 | 99,8 |
| 1.1 | Эрүүл мэндийг дэмжих-80605 | 1,165.0 | 1,165.0 | 0 | 57,8 |
| 1.2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол-81807 | 65,887.2 | 70,103.7 | -4,216.5 | 106,3 |
| 1.3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111 | 57,195.5 | 56,764.1 | 431.4 | 99,2 |
| 1.4 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816 | 4,533.7 | 4,533.7 | 0.0 | 100,0 |
| 1.5 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823 | 1,704.4 | 2,532.4 | -828.0 | 148,6 |
| 1.6 | Явуулын багшийн үйлчилгээ-81832,81833 | 18,453.6 | 5,109.4 | 13,344.2 | 27,7 |
| 1,7 | Боловсролын стандарт, сургалт-81834 | 282,853.6 | 333,818.3 | 50,964.7 | 118,0 |
| 1.8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835 | 80,080.1 | 36,731.5 | 43,348.6 | 45,9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 99,8 хувиар хэрэгжсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч, Ц.Цацрал, Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитор Ц.Саранчимэг, чанарын хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01дүгээр сарын 31-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 738,900.7 мянган төгрөгөөс 0,5 хувиар буюу 3,985.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,989.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, албан томилолтоор ажилласан зардал хэмнэж ажилласан хэдий ч байгалийн гамшиг, цас, зудын нөхцөл байдалтай уялдуулан онцгой дэглэмээр ажиллаж байгаа шалтгаан нөхцөлийн улмаас зардлын хэмнэлтийг хийх боломжгүй нөхцөл байгааг анхаарч үзсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Шилэн дансанд 2023 онд нийт 155 мэдээллийг хугацаанд нь байршуулж хугацаа хоцроож 1 мэдээлэл, 3 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв оруулж байх зөвлөмж хүргүүлэв.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Ану сервис ХХК, Элсний өгөөж хоршоо, Голден лайт старс ХХК-д мөнгөн хөрөнгөөс 119,484.6 мянган төгрөг шилжүүлсэн, 48,962.3 мянган төгрөгийн мэдээлэл шилэн дансанд байршуулсан, 58,648.9 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 25,170.6 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д " холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.2 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 1,000.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 232,742.7 мянган төгрөг, засгийн газрын оролцоо 231,742.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцооллын алдаагүй, үнэн зөв бүртгэх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ил тод нээлттэй явуулаагүй, ашиг сонирхол албан тушаалын давуу байдал үүссэн байна.ТБӨНОХБАУХА тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар цахим баримтын бүрдэл, цалингийн тооцоо, улсын бүртгэлийн хөрөнгийн дүн, зөрүүтэй зөрчлүүд, шилэн дансны талаар 2 зөрчил нийт 5 зөрчил илрүүлэн асуудлын бүртгэл хүргүүлсэн, хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар 497.9 мянган төгрөгийн 1 актын төлбөр барагдуулсан, 1975.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага 50 хувийн биелэлттэй, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|---------|----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 497.9 | 1 | 497.9 | 100 |
| Албан шаардлага | 1 | 1,975.4 | 1 | 987.7 | 50 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100 |
| Нийт дүн | | 2,473.3 | | 1,485.6 | 83.3 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж хуулийн хугацаанд нь аудитад ирүүлдэг байх, санхүүгийн тодруулга толилуулгыг үнэн зөв бэлтгэдэг байх
2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв, шударга, ил тод хийдэг байх
3. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд нийт хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна гэснийг үзэх,
4. Боловсролын шинэчлэлтийн хуулиар олгогдсон бусад эрх хэмжээний асуудлыг үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан алдаагүй, алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 3,694.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 3,694.5 төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

5.2.1 Өр төлбөрийн талаар

Илрүүлэлт: Өмнөх оны өр төлбөр үлдэгдэл 3,694.5 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”; гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.2 Үндсэн хөрөнгийн талаар

Илрүүлэлт: Аудитын түүврийн тооллогоор 777,618.9 мянган төгрөгийн хөрөнгө, бараа тоолсон. Аудитын хяналтын түүврийн тооллогоор ногооны хүлэмж, талбайн трактор, хандиваар ирсэн морин хуур гэсэн хөрөнгүүдийг бүртгэж тайлагнаагүй тодруулга тайлан бэлтгээгүй байгаа нь аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудыг бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг ханган ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг бодитой, үнэн зөв, иж бүрэн бүртгэдэг байх зөвлөмж хүргүүлэв.

5.3.2. Үндсэн хөрөнгийн талаар

Илрүүлэлт: Байгууллагын 43 нэр төрлийн 826,901.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 19 нэрийн 44,477.4 мянган төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн. Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийн тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д “Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм”, 6.13-д “Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг

¹ Өөрөөр хэлбэл, аудитын явцад залруулсан алдаагүй, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө, үүнд, математик үржүүлэлт, хувиар хувиар, өөрөөр хэлбэл мөрдөхөд өөрөөр хэлбэл, өөрөөр хэлбэл өөрөөр хэлбэл /өөрөөр хэлбэл, өөрөөр хэлбэл /өөрөөр хэлбэл, өөрөөр хэлбэл/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр, үнэн зөв бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

5.3.3. Тайлагналын талаар

Илрүүлэлт: Төсвийн захирагч нь эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, сум орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган, хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал шуурхай байдлыг эрхэмлэн ажиллахыг үүрэг болгосон. Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, тайлан ирүүлээгүй байгаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шалгуурт нийцсэн байх, санхүүгийн ухаалаг удирдлага болон төрийн албан хаагчийн зан үйл зүй зохистой байх гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль болон мөрдөгдөж байгаа бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|--|-------------|---------|---------------|-----|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн | |
| Өр төлбөр 3,694.5 мянган төгрөг барагдуулаагүй | 1 | 3,694.5 | | | 1 | 3,694.5 | | | | | | | |
| Дүн | 1 | 3,694.5 | | | 1 | 3,694.5 | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг оруулаагүй | 1 | 58,648.9 | | | 1 | 58,648.9 | | |
| Мэдээллийг бүрэн оруулж байх | 1 | | | | 1 | | | |
| Дүн | 2 | 58,648.9 | | | 2 | 58,648.9 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Засгийн газрын оролцоо сан зөрүүтэй | 1 | 231,742.7 | | | | | 1 | 231,742.7 |
| Цахим баримтын дүн илүү шивэгдсэн | 1 | 25,170.6 | | | 1 | 25,170.6 | | |
| Дүн | 2 | 256,913.3 | | | 1 | 25,154.6 | 1 | 231,742.7 |
| Нийт дүн | 4 | 315,562.2 | | | 2 | 83,819.5 | 2 | 231,742.7 |



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 57-14510516-ТӨА-2024/

Зуунмод

1258/НА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 58,648,900 /тавин найман сая зургаан зуун дөчин найман мянга есөн зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 3 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040623

2. Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч А.Атарцэцэг, нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 149-14510516-ТӨА 2024

Зуунмод

1258/НА-СТА-МУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 25,170,600 /хорин таван сая нэг зуун далан мянга зургаан зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

0190/2024

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч А.Атарцэцэг, нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn